**07- р сар**

I. Төсвийн орлого
II. Төсвийн орлого, /сумаар/
III. Төсвийн зарлага
IV. Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
V. Ажил хайгч иргэд
VI. Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны зуучлал
VII. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт
VIII. Нийгмийн даатгалын орлого
IX. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо
X. Хэрэглээний үнийн индекс
XI. Аж үйлдвэрийн үнэ
XII. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
XIII. Хөдөө аж ахуйн үнэ
XIV. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
XV. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
XVI. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ тариф
XVII. Гэмт хэрэг зөрчил /сумдаар/

# Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал
# (2018 оны 7 сарын байдлаар)

I.Төсвийн орлого

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 7-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 86.9 хувьтай буюу 4132.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 71.6 хувьтай буюу 893.0 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 5056.9 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 83.7 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 24622.7 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 98.5 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 4501.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 14608.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1349.3 сая төгрөг нийт 20458.7 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Дэрэн, Баянжаргалан, Өндөршил, Луус, Дэлгэрхангай, Сайхан-овоо, Сайнцагаан, Адаацаг сумд 3.1-54.2 хувиар буюу 2.1-80.1 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бол бусад сумд төлөвлөгөөгөө 1.2-74.4 хувиар тасалдуулсан байна.

II.Төсвийн зарлага

2018 оны 7 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 20850.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 хувиар буурсан байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 11185.6 сая төгрөг болж нийт зардлын 53.6 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 11.8 хувиар өсч 1319.3 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үеэс эд хогшил урсгал засварын зардал 62.3 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10.1 хувиар, хангамжийн бараа материалын зардал 18.7 хувиар,

томилолтын зардал 18.7 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 36.1 хувиар өссөн бол норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал, хөрөнгийн зардал бүгд 1-23.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

III.Банк

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өсч 96221.0 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1154.7 сая төгрөг, чанаргүй зээл 929.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 28.1 хувиар, чанаргүй зээл 46.0 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 2.2 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар өсч 50142.3 сая төгрөг болов.

IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд

2018 оны 7 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил хайж байгаа 575 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 412 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 52.3 хувь буюу 301 нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 188 ажилгүйчүүд ногдож байхад Говь-Угтаал 684, Баянжаргалан 370, Хулд 329 , Гурвансайхан 276, Өлзийт 274 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна. Ажил хайгч иргэдийн 0.5 хувь нь магистр доктор, 13.4 хувь нь дипломын болон баклаврын дээд, 3.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 7.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 39.3 хувь нь бүрэн дунд, 24.5 хувь нь суурь, 9.7 хувь нь бага, 2.4 хувь нь боловсролгүй иргэд байна. Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 3.7 хувь буюу 21 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бол 57.2 хувь нь 25-34 насны залуучууд байна.

V.Ажлын байрны зуучлал

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2018 оны 7 сарын мэдээгээр нийт 250 хүн ажлын байранд зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч

үзэхэд удирлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 22.8 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 40.8 хувь, Төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт 4.4 хувь, боловсролын салбарт 8.4 хувь, санхүү даатгалын салбарт тус бүр 3.6 хувь нь зуучлагдсан  бол үлдсэн хувь нь хөдөө аж ахуй, уул уурхай, эрүүл мэнд, урлаг соёлын  салбарт зуучлагджээ.

## VI. Нийгмийн халамж

2018 оны 7 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 13485 хүнд 3383.7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 32.9% буюу 4434 нь алдарт эхийн одонтой эхчүүд бөгөөд 617.1  сая төг, 18.1 % буюу 2446 нь насны хишиг тэтгэмж авч буй ахмадууд 403.9 сая төг, 19.1 % буюу 2577 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдэд 700.1 сая төг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 858 иргэн 352.2 сая төгрөг, Халамжийн тэтгэвэрийг 791 иргэн 756.2 сая төгрөг, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй 895 эхэд 103.5 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

## VII. Нийгмийн даатгал

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны 7 сарын байдлаар 16844.5 сая төгрөг, зарлага 16915.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 1254.9 сая төгрөг буюу 8 хувиар өсч, зарлага 1916.4 сая төгрөг буюу 12.8 хувиар өслөө. Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2018 оны 7 сарын байдлаар 9786 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2001 хүн буюу 20.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3890 хүн буюу 39.8 хувь нь төсөвт байгууллагаас, 3895  хүн буюу 39.8 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж ахуй нэгж, байгууллагын даатгуулагч болон сайн дурын даатгуулагчын тоо буурч, төсөвт байгууллагын даатгуулагчын тоо өссөн дүнтэй байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2018 оны 7 сарын байдлаар  14718.6 сая төг болж, үүний 82.6 хувийг өндөр настны, 11.5 хувийг хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн, 2.8 хувийг тэжээгчээ алдсаны, 3.1 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны 7 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6824 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 81.8 хувь буюу 5584 хүн өндөр насны, 12.8 хувь буюу 875 хүн тахир дутуугийн, 3.5 хувь буюу 242 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 123 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна. Энэ оны 7 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 1437, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 27, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 159 хүн байна. 7 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 16144 байгаагийн 60.0 хувь буюу 9682 төр хариуцах иргэд, 25.3 хувь буюу 4094 малчид, 11.3 хувь буюу 1817 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 3.4 хувь буюу 551 оюутан суралцагсад байна. 2018 оны 7 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 6377.3 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 26.5 хувиар буюу 1336.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Гурвансайхан сумаас бусад бүх сумд давуулан биелүүлсэн байна.

## VIII. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2018 оны 7 сарын байдлаар 566 эх төрсөн нь өнгөрсөн мөн үеэс 74 төрөлтөөр өссөн ба нийт 572 хүүхэд амьд төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 90.6 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ оны байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

2018 оны 7 сарын байдлаар 1 хүртлэх насны нялхсын эндэгдэл 5 байгаа нь Дэлгэрцогт, Гурвансайхан, Хулд сум болон аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн байна. Нас баралтын 160 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 25 тохиолдлоор өсчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 32.7 хувийг эзэлж байна. Энэ оны 7 сарын байдлаар стационарит шинээр 6751 эмчлүүлэгч хэвтэж, 6815 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 49288 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.2 байна. 2018 оны 7 сарын байдлаар 99942 үзлэг бүртгэгдсэнээс

урьдчилан сэргийлэх үзлэг 28.2%, амбулаторийн үзлэг 47.3%, идэвхитэй хяналт 16.6%, гэрийн үзлэг 5.3 %, гэрийн дуудлага 2.6%-ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.5 хувь нь эрэгтэй, 64.5 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 240 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 89 тохиолдлоор буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 55.2 болж өмнөх оны мөн үеэс 17.5 пунктээр буурсан байна.

## IX.Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ,үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2018 оны 7-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2017 оны 7-р сартай харьцуулахад 7.3 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 7.3 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 17.6 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 11.9 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 6.0 хувь өссөн, орон сууц, ус , цахилгаан, түлшний бүлэг 2.4 хувь өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 3.8 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 10.1 хувь, тээврийн бүлэг 5.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2018 оны 7 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин , дизель түлш болон ноолуурын үнийг оруууллаа.

## ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

| № | Барааны нэр, төрөл | VII/04 | VII/11 | VII/18 | VII/25 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, 1-р зэрэг, кг | 1200 | 1200 | 1200 | 1200 |
| 2 | Хонины мах, кг | 7500 | 7500 | 7500 | 7500 |
| 3 | Үхрийн мах, кг | 0 | 0 | 0 | 0 |
| 4 | Ямааны ястай мах, кг | 6500 | 6500 | 6500 | 6800 |
| 5 | Элсэн чихэр, кг | 2000 | 2000 | 2000 | 2000 |
| 6 | Цагаан будаа, кг | 2300 | 2300 | 2300 | 2300 |
| 7 | Шингэн сүү, л | 2500 | 2500 | 2500 | 2500 |
| 8 | Ноолуурын үнэ 1 кг | 90000 | 90000 | 85000 | 85000 |
| 9 | Бензин А-80, 1литр | 1750 | 1750 | 1750 | 1750 |
| 10 | Бензин А-92, 1литр | 1880 | 1880 | 1880 | 1880 |
| 11 | Дизель түлш 1 литр | 2220 | 2220 | 2220 | 2220 |

## X. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 оны 7 сарын байдлаар 4091.8 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3.8 хувиар буурсан байна.

## XI. Гэмт хэрэг

Цагдаагийн хэлтсийн 2018 оны 7 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 169 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34.1 хувь өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буурч, 74 хүн холбогдоод байна. 2018 оны 7 сарын байдлаар танхайрах, булаалт, дээрэм , албан тушаалын гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, хүчингийн хэрэг, бусдын эд хөрөнгийн хулгайн хэрэг,залилангийн хэрэг, бусад хэрэг нэмэгдсэн байна. Харин хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын хэрэг, дээрмийн хэрэг, малын хулгайн хэрэг буурсан байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 29.5 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын хэрэг, 42.0 хувийг хулгайн, 10.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний

аюулгүй байдлын эсрэг, 1.2 хувийг хүнийг санаатай алах хэрэг, 3.5 хувийг хүчиндэх, залилангийн хэрэг 3.6 хувийг, 2.4 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 7.7 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 13.0 хувийг согтуугаар, 3.6 хувийг эмэгтэй хүн оролцсон, 7.1 хувийг бүлэглэж, 2.9 хувийг хүүхэд оролцож хэрэг үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 8 хүн байхад Дэлгэрцогт 9,  Сайнцагаан 18, ,Өндөршил 10 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 401.2 сая төгрөг, түүний 48.8 хувь буюу 195.8 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 57,7 хувиар буурч 37,4 болсон байна.

## XII. Байгаль орчин

### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Агаарын температурын сарын дундаж нь нийт нутгаар 15-20 градус буюу уур амьсгалын дунджаас 1.0-1.5 градусаар дулаан байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр бүх нутгаар шөнөдөө 15-20 градус өдөртөө 32-37 градус хүрч халах төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүсч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 5-10 градус өдөртөө 17-22 градус, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус өдөртөө 22-27 градус дулаан байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 13-18 градус өдөртөө 26-31 градус дулаан байна.

Энэ сард нутгийн баруун хэсгээр уур амьсгалын дунджийн орчим, бусад нутгаар уг дунджаас бага бороо орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхээр ихэнх нутгаар бороо, нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эцсээр зарим газраар түр зуур 18-20 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.

# I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2018.08.08

| Үзүүлэлт | мөр | 2017 VII | 2018 VII | | | 18/17 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төл | гүйц | хувь | хувь |
| Нийт орлого /тусламжийн дүн/ | 1 | 22312404.9 | 25001830.0 | 24622659.9 | 98.5 | 110.4 |
| А.УРСГАЛ ОРЛОГО | 2 | 3540004.7 | 4754937.7 | 4132553.9 | 86.9 | 116.7 |
| I.ТАТВАРЫН ОРЛОГО | 3 | 2245988.4 | 2659323.2 | 2473849.8 | 93.0 | 110.1 |
| 1.1 Хүн амын орлогын албан татвар | 4 | 1706565.2 | 2089681.3 | 1809484.6 | 86.6 | 106.0 |
| 1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар | | 1823570.9 | 2105267.7 | 1747636.9 | 83.0 | 95.8 |
| Хувь хүний орлогын албан татварын буцаалт | | -436797.4 | -450000.0 | -427269.9 | 94.9 | 97.8 |
| 1.2 үйл ажиллагааны орлого | 5 | 294668.8 | 175927.4 | 188581.8 | 107.2 | 64.0 |
| 1.3 Хөрөнгө борлуулсаны | 6 | 24839.9 | 30000.0 | 17828.2 | 59.4 | 71.8 |
| 1.4 Орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэний | 7 | 0.0 | 0.0 | 0.0 | - | - |
| 1.5 Бусад татвар | 8 | 283.0 | 228486.2 | 282707.6 | 123.7 | - |
| 2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/ | 9 | 51314.4 | 64173.8 | 70470.5 | 109.8 | 137.3 |
| 3. Авто тээврийн хэрэгслийн | 12 | 222788.6 | 243653.8 | 225215.2 | 92.4 | 101.1 |
| 4. Бусад татвар | 13 | 265320.2 | 261814.3 | 368679.5 | 140.8 | 139.0 |
| 4.1 Улсын тэмдэгтийн | 14 | 65212.7 | 71172.9 | 105904.6 | 148.8 | 162.4 |
| 4.2 Ашигт малтмал нөөцийн | 15 | 11403.2 | 15867.2 | 40551.5 | - | 355.6 |
| 4.3 Газрын төлбөр | 16 | 98706.1 | 96412.0 | 129463.2 | 134.3 | 131.2 |
| 4.5 Хог хаягдалын үйлчилгээний | 17 | 11641.7 | 25914.4 | 9304.5 | 35.9 | 0.0 |
| 4.6 Усны төлбөр | 18 | 5337.0 | 10590.0 | 29919.2 | 0.0 | 0.0 |
| 4.7 Лиценцийн төлбөр | 19 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 4.6.Бусад | 20 | 73019.5 | 41857.8 | 53536.5 | 0.0 | 73.3 |
| II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 19 | 1294016.3 | 2095614.5 | 1658704.1 | 79.2 | 101.6 |
| 2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 22 | 1104705.7 | 1870661.3 | 1369587.7 | 73.2 | 124.0 |
| 2.2 Бусад нэр заагдаагүй | 23 | 189310.6 | 224953.2 | 289116.4 | 128.5 | 152.7 |
| Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 24 | 8956.4 | 41000.0 | 31371.4 | 0.0 | 0.0 |
| В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 26 | 18763443.8 | 20205892.3 | 20458734.6 | 101.3 | 109.0 |
| 1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 28 | 3601599.6 | 4501331.8 | 4501331.6 | 100.0 | 125.0 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | 13916251.8 | 14608103.3 | 14608103.3 | 100.0 | 105.0 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих | | 1245592.4 | 1096457.2 | 1349299.7 | 123.1 | 108.3 |
| Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй / | 29 | 3548961.1 | 4795937.7 | 4163925.3 | 86.8 | 117.3 |
| Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого | 30 | 1840289.9 | 1247909.4 | 893002.4 | 71.6 | 48.5 |
| Аймгийн нийт орлого | 31 | 5389251.0 | 6043847.1 | 5056927.7 | 83.7 | 93.8 |

## II.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ САР БҮРИЙН ЭЦЭСТ, мянган төгрөгөөр

| Сумд | 2018 I-VII | | | 2018 VII сар | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь |
| Дэлгэрцогт | 69333.7 | 60759.3 | 87.6 | 7840.0 | 5104.5 | 65.1 |
| Дэрэн | 70236.0 | 74495.5 | 106.1 | 8000.5 | 8347.3 | 104.3 |
| Говь-Угтаал | 178552.2 | 86667.7 | 48.5 | 8720.0 | 9102.9 | 104.4 |
| Цагаандэлгэр | 51900.9 | 46295.4 | 89.2 | 5425.0 | 8551.3 | 157.6 |
| Баянжаргалан | 276589.9 | 356724.4 | 129.0 | 18520.0 | 19905.3 | 107.5 |
| Өндөршил | 85563.0 | 90352.3 | 105.6 | 9509.9 | 6876.7 | 72.3 |
| Гурвансайхан | 667067.6 | 170495.6 | 25.6 | 13728.4 | 24414.0 | 177.8 |
| Өлзийт | 176533.4 | 114017.7 | 64.6 | 10008.0 | 16132.9 | 161.2 |
| Хулд | 137474.0 | 111580.7 | 81.2 | 19148.5 | 15658.2 | 81.8 |
| Луус | 67462.2 | 87054.7 | 129.0 | 6312.1 | 5180.1 | 82.1 |
| Дэлгэрхангай | 97599.7 | 149651.2 | 153.3 | 10211.8 | 12115.3 | 118.6 |
| Сайхан-Овоо | 68218.7 | 70357.2 | 103.1 | 9879.3 | 4011.7 | 40.6 |
| Эрдэнэдалай | 184964.6 | 182670.1 | 98.8 | 19060.0 | 12338.6 | 64.7 |
| Сайнцагаан | 401493.2 | 426916.2 | 106.3 | 43886.6 | 38985.5 | 88.8 |
| Адаацаг | 75250.4 | 116031.2 | 154.2 | 7325.0 | 8788.5 | 120.0 |
| Дундговь | 1583637.3 | 2017294.9 | 127.4 | 224268.0 | 238108.3 | 106.2 |
| Дүн | 4191876.8 | 4161364.1 | 99.3 | 421843.1 | 433621.1 | 102.8 |

## III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2018.08.08

| Зарлагын төрөл | 2017 VII | 2018 VII | | | 18VII /17 VII |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Орон нутгийн байгууллагын зарлагын дүн | 23178740.8 | 26626054.0 | 20850850.9 | 78.3 | 90.0 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 10917219.3 | 11693454.2 | 11185626.4 | 95.7 | 102.5 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1180338.0 | 1390038.9 | 1319322.0 | 95.7 | 111.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1736736.8 | 2189384.2 | 1912621.9 | 94.9 | 110.1 |
| Хангамж бараа материалын зардал | 313360.3 | 455742.9 | 371907.0 | 81.6 | 118.7 |
| Норматив зардал | 618656.4 | 775285.8 | 612762.4 | 79.0 | 99.0 |
| Эд хогшил урсгал засварын зардал | 131442.7 | 320528.3 | 213309.9 | 66.5 | 162.3 |
| Томилолтын зардал | 69147.4 | 93982.3 | 82061.8 | 87.3 | 118.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 396649.0 | 531297.1 | 539664.3 | 101.6 | 136.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1179604.9 | 3267166.1 | 929087.6 | 28.4 | 78.8 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 2235894.3 | 139129.8 | 132373.4 | 95.1 | 5.9 |
| Бусад урсгал шилжүүлэг | 3109886.5 | 3255648.3 | 2371826.1 | 72.9 | 76.3 |
| Хөрөнгийн зардал | 1289805.2 | 2514396.1 | 1180288.1 | 46.9 | 91.5 |

## IV.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

| № | Үзүүлэлт | ХААН банк | | Хас банк | | Төрийн банк | | Капитал банк | | Бүгд | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2017 VII | 2018 VII | 2017 VII | 2018 VII | 2017 VII | 2018 VII | 2017 VII | 2018 VII | 2017 VII | 2018 VII | 2018/ 2017 хувь |
| 1 | Кассын орлого Зузаатгалаар | 8,341.50 | 8,961.80 | 800.5 | 657.7 | 5973.7 | 4799.3 | 0.0 | 0.0 | 15115.7 | 14418.8 | 95.4 |
| | Кассын зарлага шилжүүлсэн | 7,216.00 | 6,724.40 | 1868.1 | 2450.1 | 3549.9 | 4620.6 | 190.0 | 125.5 | 12824.0 | 13920.6 | 108.6 |
| 2 | Зээлийн өрийн үлдэгдэл | 51939.0 | 57387.2 | 10529.0 | 11148.6 | 25229.0 | 27615.5 | 78.9 | 69.7 | 87775.9 | 96221.0 | 109.6 |
| 3 | үүнээс: Анхаарал хандуулах зээл | 334.5 | 269.2 | 504.9 | 742.0 | 57.9 | 143.5 | 3.8 | 0.0 | 901.1 | 1154.7 | 128.1 |
| | чанаргүй зээл | 436.9 | 381.6 | 128.1 | 494.1 | 43.9 | 36.8 | 28.0 | 17.4 | 636.9 | 929.9 | 146.0 |
| 4 | Иргэдийн хувийн хадгаламжийн үлдэгдэл | 26299.4 | 34915.9 | 4145.6 | 3846.0 | 9539.8 | 10826.6 | 344.5 | 553.8 | 40329.3 | 50142.3 | 124.3 |

# V.АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2018.08.08

| Сум | Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам | Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд | Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд | Үүнээс эмэгтэй | Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд |
|---|---|---|---|---|---|
| Дэлгэрцогт | 1106 | 12 | 6 | 0 | 54 |
| Дэрэн | 1363 | 21 | 25 | 7 | 183 |
| Говь-Угтаал | 1068 | 13 | 73 | 34 | 684 |
| Цагаандэлгэр | 694 | 4 | 10 | 7 | 144 |
| Баянжаргалан | 756 | 14 | 28 | 10 | 370 |
| Өндөршил | 973 | 2 | 3 | 2 | 31 |
| Гурвансайхан | 1449 | 38 | 40 | 14 | 276 |
| Өлзийт | 1607 | 22 | 44 | 23 | 274 |
| Хулд | 1612 | 55 | 53 | 31 | 329 |
| Луус | 1239 | 0 | 11 | 8 | 89 |
| Дэлгэрхангай | 1489 | 23 | 13 | 4 | 87 |
| Сайхан-Овоо | 1470 | 6 | 11 | 7 | 75 |
| Эрдэнэдалай | 3685 | 46 | 47 | 26 | 128 |
| Сайнцагаан | 10074 | 126 | 194 | 124 | 193 |
| Адаацаг | 1943 | 17 | 17 | 4 | 87 |
| Дүн | 30528 | 399 | 575 | 301 | 188 |

## VI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2018 оны 7 сарын байдлаар

2018.08.08

| Эдийн засгийн салбарын ангилал | Ажилд зуучилсан иргэд | үүнээс: эмэгтэй | Эдийн засгийн салбарын эзлэх % |
|---|---|---|---|
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй | 15.0 | 1.0 | 6.0 |
| Уул уурхай олборлох үйлдвэр | 1.0 | 1.0 | 0.4 |
| Боловсруулах аж үйлдвэр | 3.0 | 1.0 | 1.2 |
| Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт | 1.0 | 1.0 | 0.4 |
| Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог | 3.0 | 1.0 | 1.2 |
| Барилга | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бөөний ба жижиглэн худалдаа | 11.0 | 8.0 | 4.4 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зочид буудал, зоогийн газар | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэдээлэл холбоо | 2.0 | 1.0 | 0.8 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 9.0 | 7.0 | 3.6 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 57.0 | 18.0 | 22.8 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа | 11.0 | 9.0 | 4.4 |
| Боловсрол | 21.0 | 13.0 | 8.4 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 11.0 | 6.0 | 4.4 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 3.0 | 3.0 | 1.2 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 102.0 | 27.0 | 40.8 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бүгд | 250.0 | 97.0 | 100.0 |

# VII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВРИЙН САНХҮҮЖИЛТ, 2018 оны 7 сарын байдлаар

2018.08.08

| Сумд | Н.Д.Шимтгэлийн орлого /мян.төг/ | | | Тэтгэврийн санхүүжилт /мян.төг/ | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төл | гүйц | хувь | олгох | олгосон | хувь |
| Дэлгэрцогт | 96723.2 | 147464.1 | 152.5 | 594447.0 | 594447.0 | 100.0 |
| Дэрэн | 96554.8 | 151777.5 | 157.2 | 633593.3 | 633593.3 | 100.0 |
| Говь-Угтаал | 119924.5 | 167540.8 | 139.7 | 518959.0 | 518959.0 | 100.0 |
| Цагаандэлгэр | 75056.1 | 96775.3 | 128.9 | 299156.3 | 299156.3 | 100.0 |
| Баянжаргалан | 142103.0 | 177131.8 | 124.7 | 312361.4 | 312361.4 | 100.0 |
| Өндөршил | 109542.0 | 161222.0 | 147.2 | 409514.6 | 409514.6 | 100.0 |
| Гурвансайхан | 201149.8 | 175062.2 | 87.0 | 574911.1 | 574911.1 | 100.0 |
| Өлзийт | 117835.8 | 203962.8 | 173.1 | 711629.4 | 711629.4 | 100.0 |
| Хулд | 144587.1 | 220359.9 | 152.4 | 675329.9 | 675239.9 | 100.0 |
| Луус | 114931.3 | 186002.4 | 161.8 | 571061.4 | 571061.4 | 100.0 |
| Дэлгэрхангай | 138511.4 | 229460.6 | 165.7 | 678176.4 | 678176.4 | 100.0 |
| Сайхан-Овоо | 97506.5 | 155609.3 | 159.6 | 548051.4 | 548051.4 | 100.0 |
| Эрдэнэдалай | 277517.4 | 455028.3 | 164.0 | 1747512.5 | 1747512.5 | 100.0 |
| Адаацаг | 135523.9 | 206990.8 | 152.7 | 795214.2 | 795214.2 | 100.0 |
| Сайнцагаан | 3173547.5 | 3642951.4 | 114.8 | 5648673.5 | 5648673.5 | 100.0 |
| Дүн | 5041014.3 | 6377339.2 | 126.5 | 14718591.4 | 14718501.4 | 100.0 |

## VIII.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 7 сарын байдлаар

2018.08.08 /сая.төг/

| | 2017 оны VII сар | 2018 оны VII сар | | | 2018 VII / 2017 VII хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 15589.6 | 5041.0 | 16844.5 | 334.1 | 108.0 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 12522.3 | 4205.2 | 14643.9 | 348.2 | 116.9 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 652.3 | 457.1 | 704.8 | 154.2 | 108.0 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 1868.0 | 0.0 | 1081.6 | 0.0 | 57.9 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 322.1 | 292.7 | 269.0 | 91.9 | 83.5 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 224.9 | 86.0 | 145.2 | 168.8 | 64.6 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | 14998.7 | 16417.4 | 16915.1 | 103.0 | 112.8 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 12457.6 | 15244.2 | 14672.9 | 96.3 | 117.8 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 595.8 | 707.0 | 738.0 | 104.4 | 123.9 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 1455.6 | 0.0 | 1100.2 | 0.0 | 75.6 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 292.5 | 262.6 | 246.9 | 94.0 | 84.4 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 197.2 | 203.6 | 157.1 | 77.2 | 79.7 |

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

# IX.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ

2018.08.08

| Үзүүлэлтүүд | | 2016 оны VII сар | 2017 оны VII сар | 2018 оны VII сар | 2018VII / 2017VII хувь |
|---|---|---|---|---|---|
| Заавал даатгуулагчийн тоо | | 11891 | 10097 | 9786 | 96.9 |
| Үүнээс: | | | | | |
| | Аж ахуйн нэгж, байгууллага | 2098 | 2156 | 2001 | 92.8 |
| | Төсөвт байгууллага | 3746 | 3855 | 3890 | 100.9 |
| | Сайн дурын | 6047 | 4086 | 3895 | 95.3 |
| Олгосон тэтгэвэр, сая төг | | 11943.7 | 12502.5 | 14718.6 | 117.7 |
| Үүнээс: | | | | | |
| | Өндөр настны | 9738.8 | 10284.6 | 12158.5 | 118.2 |
| | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн | 1516.7 | 1488.8 | 1687.3 | 113.3 |
| | Тэжээгчээ алдсаны | 354.2 | 374.1 | 418.7 | 111.9 |
| | Цэргийн | 334.0 | 355.0 | 454.1 | 127.9 |

## XV. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2018.08.08

| Барааны бүлгээр | 2018 VII / 2017 VII | 2018 VII / 2017 XII |
|---|---|---|
| ЕРӨНХИЙ ИНДЭКС | 107.3 | 104.5 |
| 01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 117.6 | 115.3 |
| 01.1 ХҮНСНИЙ БАРАА | 118.8 | 116.2 |
| 01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | 101.7 | 101.2 |
| 01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | 148.8 | 163.4 |
| 01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН | 109.3 | 101.2 |
| 01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | 113.0 | 92.3 |
| 01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС | 101.8 | 100.5 |
| 01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ | 119.0 | 96.3 |
| 01.1.7 ХҮНСНИЙ НОГОО | 161.7 | 159.1 |
| 01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР | 97.1 | 99.8 |
| 01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН | 109.9 | 104.5 |
| 01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 105.8 | 105.7 |
| 02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС | 111.9 | 108.5 |
| 02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА | 108.5 | 106.3 |
| 02.2 ТАМХИ | 116.9 | 111.9 |
| 03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ | 106.0 | 102.4 |
| 03.1 ХУВЦАС, БӨС БАРАА | 107.1 | 103.2 |
| 03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА | 108.2 | 101.3 |
| 03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС | 107.1 | 103.5 |
| 03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ | 105.4 | 100.0 |
| 03.2 ГУТАЛ | 103.6 | 100.7 |
| 04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 102.4 | 95.4 |
| 04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС | 105.4 | 105.4 |
| 04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 103.1 | 102.1 |
| 04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 04.4 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 102.2 | 92.2 |

| Барааны бүлгээр | | 2018 VII / 2017 VII | 2018 VII / 2017 XII |
|---|---|---|---|
| **05.** | **ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА** | **103.8** | **102.5** |
| | 05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР | **104.7** | **103.3** |
| | 05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ | **106.0** | **106.0** |
| | 05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА | **97.3** | **101.4** |
| | 05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА | **110.7** | **105.4** |
| | 05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ | **102.5** | **99.6** |
| | 05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД | **103.4** | **100.9** |
| **06.** | **ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **110.1** | **108.3** |
| | 06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ | **112.0** | **109.8** |
| | 06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |
| | 06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |
| **07.** | **ТЭЭВЭР** | **105.4** | **104.5** |
| | 07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ | **102.2** | **101.0** |
| | 07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ | **111.7** | **111.6** |
| | 07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |
| **08.** | **ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.0** | **100.0** |
| | 08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ | **100.0** | **100.0** |
| | 08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |
| **09.** | **АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ** | **102.2** | **102.2** |
| | 09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМ | **101.9** | **100.5** |
| | 09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |
| | 09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ | **104.5** | **105.1** |
| **10.** | **БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.1** | **100.0** |
| **11.** | **ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.8** | **100.8** |
| | 11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | **102.0** | **102.0** |
| | 11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |
| **12.** | **БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** | **105.8** | **101.1** |
| | 12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ | **107.0** | **101.2** |
| | 12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ | **102.1** | **101.1** |
| | 12.5 ДААТГАЛ | **100.0** | **100.0** |
| | 12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | **100.0** | **100.0** |

XI. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 7-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/

2018.08.08

| | Нэр төрөл | Дундговь | Төв | Өмнөговь | Дорноговь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, дээд зэрэг /Алтантариа/ | 1475.0 | 1433.0 | 1647.0 | 1367.0 |
| 2 | Гурил, 1-р зэрэг /Алтантариа/ | 1200.0 | 1167.0 | 1233.0 | 1100.0 |
| 3 | Гурил, 2-р зэрэг /Алтантариа/ | 950.0 | 925.0 | 0.0 | 950.0 |
| 4 | Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай | 783.0 | 750.0 | 887.0 | 783.0 |
| 5 | Талх, орон нутгийн үйлдвэрийн | 1033.0 | 1200.0 | 1033.0 | 1400.0 |
| 6 | Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/ | 1650.0 | 1200.0 | 2367.0 | 2000.0 |
| 7 | Жигнэмэг /Юбилейные 150-180г, цайны/ | 1200.0 | 1233.0 | 1183.0 | 1167.0 |
| 8 | Цагаан будаа, задгай, кг | 2250.0 | 2367.0 | 2333.0 | 2200.0 |
| 9 | Шар будаа, задгай, кг | 1700.0 | 1700.0 | 1700.0 | 1933.0 |
| 10 | Хонины мах, кг | 7500.0 | 7167.0 | 7833.0 | 6933.0 |
| 11 | Адууны мах, кг | 0.0 | 7000.0 | 8000.0 | 7000.0 |
| 12 | Ямааны мах, кг | 6500.0 | 5000.0 | 7333.0 | 5933.0 |
| 13 | Дотор мах, цувдай, цусгүй | 2000.0 | 3250.0 | 5000.0 | 2500.0 |
| 14 | Хиам чанасан, 1кг | 7667.0 | 8333.0 | 9100.0 | 6600.0 |
| 15 | Сүү, задгай, л | 2500.0 | 1067.0 | 4000.0 | 2000.0 |
| 16 | Сүү савласан,1л. Цэвэр сүү | 2800.0 | 2650.0 | 2600.0 | 2567.0 |
| 17 | Хорхой ааруул, задгай, чихэртэй | 18000.0 | 13250.0 | 15000.0 | 14500.0 |
| 18 | Өндөг,ш,дотоод | 270.0 | 300.0 | 313.0 | 300.0 |
| 19 | Ургамлын тос, 1литр, Кларина | 3400.0 | 3967.0 | 3313.0 | 3133.0 |
| 20 | Өөхөн тос, кг | - | 1300.0 | - | - |
| 21 | Шар тос, кг | 15000.0 | 20000.0 | 14000.0 | 16667.0 |
| 22 | Цөцгийн тос, задгай, кг | 3533.0 | 4000.0 | 3933.0 | 3567.0 |
| 23 | Төмс дотоод, кг | 2067.0 | 2200.0 | 3433.0 | 1867.0 |
| 24 | Лууван хятад, кг | 2250.0 | 2833.0 | 1967.0 | 2000.0 |
| 25 | Байцаа хятад, кг | 2100.0 | 1833.0 | 1667.0 | 1933.0 |
| 26 | Сонгино хятад, кг | 2100.0 | 1467.0 | 1300.0 | 1500.0 |
| 27 | Элсэн чихэр, кг, орос | 1900.0 | 1833.0 | 2000.0 | 1933.0 |
| 28 | Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/ | 5300.0 | 5500.0 | 5600.0 | 5500.0 |
| 29 | Зөөлөн чихэр, /Мишка/, кг | - | 14500.0 | 9333.0 | 9750.0 |
| 30 | Шоколад, "Alpen gold" | 2167.0 | 2200.0 | 2057.0 | 2033.0 |
| 31 | Давс, цагаан, 1 кг, йоджуулсан | 800.0 | 1000.0 | 767.0 | 700.0 |
| 32 | Майноз, /Золотой 500г/ | 2800.0 | 4500.0 | 4433.0 | 4500.0 |
| 33 | Кетчуп, 900г, Чили | 2000.0 | 1900.0 | 1957.0 | 1933.0 |
| 34 | Ногоон цай, Stimo, савласан 90г | 1750.0 | 1650.0 | 1100.0 | - |
| 35 | Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй | 1650.0 | 1667.0 | 1580.0 | 1567.0 |
| 36 | Цагаан архи, 0.5 Ерөөл | 8167.0 | 8567.0 | 8197.0 | 8767.0 |
| 37 | Пиво, "Боргио", 0.5л | 1617.0 | 1700.0 | 1850.0 | 1700.0 |
| 38 | Янжуур тамхи, /West/, саарал | 2933.0 | 2900.0 | 2917.0 | 2733.0 |
| 39 | Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи | 2100.0 | 2000.0 | 1930.0 | 1767.0 |
| 40 | Бензин, А-80, 1 литр | 1770.0 | 1643.0 | 1745.0 | 1728.0 |
| 41 | Бензин, А-92, 1 литр | 1880.0 | 1797.0 | 1928.0 | 1855.0 |
| 42 | Дизель түлш, 1 литр | 2217.0 | 2090.0 | 2238.0 | 2195.0 |

XII. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр )

2018.08.08 мян.төг

| Аж үйлдвэрийн салбар | 2017 | 2018 | 2018/2017 хувь |
|---|---|---|---|
| **Нийт дүн** | **4254640.2** | **4091789.1** | **96.2** |
| **Уул уурхайн олборлох аж үйлдвэр** | **1646998.8** | **1071132.1** | **65.0** |
| Нүүрс олборлолт | 164868.8 | 181964.5 | 110.4 |
| Гөлтгөнө | 0.0 | 266340.0 | - |
| Жонш олборлолт | 1482130.0 | 622827.6 | 42.0 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **655163.6** | **682676.6** | **104.2** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 538351.6 | 526094.0 | 97.7 |
| Хуснэгт маягт үйлдвэрлэл | 10047.0 | 12259.1 | 122.0 |
| Боловсруулах үйлдвэр бусад | 106765.0 | 144323.5 | 135.2 |
| **Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж** | **1952477.8** | **2337980.4** | **119.7** |
| *Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл* | 1552258.3 | 2000049.4 | 128.8 |
| Ус ариутгал ус хангамж | 400219.5 | 337931.0 | 84.4 |

# XIII. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2018.08.08

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2017 оны мөн үед | 2018 онд | 2018/2017 хувь |
|---|---|---|---|---|
| Хүрэн нүүрс | мян.тн | 6.5 | 7.5 | 115.4 |
| Жонш | мян.тн | 10.8 | 3.6 | 33.3 |
| Гөлтгөнө | мян.тн | 0.0 | 10.7 | - |
| Дулааны эрчим хүч | мян.гкал | 49.4 | 45.1 | 91.3 |
| Хүснэгт, маягт | х.д.х | 143.9 | 175.0 | 121.6 |
| Талх | тн | 68.0 | 77.3 | 113.7 |
| Нарийн боов | тн | 73.4 | 59.7 | 81.3 |
| Чихэр | тн | 2.6 | 1.5 | 57.7 |
| Архи | мян.л | 17.4 | 17.4 | 100.0 |
| Хиамны зүйл | тн | 0.4 | 0.1 | 25.0 |
| Сүү, тараг | мян.л | 3.1 | 3.0 | 96.8 |
| Хоормог | мян.л | 0.0 | 0.0 | - |
| Ааруул | тн | 0.6 | 0.3 | 50.0 |
| Вакум цонх | $м^2$ | 77.0 | 126.0 | 163.6 |
| Вакум хаалга | $м^2$ | 20.0 | 42.0 | 210.0 |
| Модон эдлэл | мян.төг | 49413.0 | 99140.0 | 200.6 |
| Түгээсэн цэвэр ус | $мян.т^3$ | 68.9 | 60.9 | 88.4 |
| Сувагжуулалт | $мян.м^3$ | 46.7 | 41.2 | 88.2 |
| Оёдол эсгүүр | мян.төг | 48195.0 | 33992.5 | 70.5 |
| Блок | мян.ш | 1.7 | 4.2 | 247.1 |

# XIV. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2018.08.08

| сумд | төрсөн хүүхдийн тоо | | Бүх нас баралт | | 0-1 насны хүүхдийн эндэгдэл | | 1-5 насны хүүхдийн эндэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 |
| Дэлгэрцогт | 0 | 1 | 7 | 7 | 0 | 1 | 0 | 1 |
| Дэрэн | 2 | 3 | 5 | 7 | 1 | 0 | 1 | 0 |
| Говь-Угтаал | 7 | 5 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 |
| Цагаандэлгэр | 1 | 0 | 1 | 3 | 0 | 0 | 0 | 1 |
| Баянжаргалан | 0 | 0 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 |
| Өндөршил | 1 | 2 | 7 | 3 | 0 | 0 | 0 | 0 |
| Гурвансайхан | 2 | 0 | 4 | 9 | 0 | 1 | 0 | 1 |
| Өлзийт | 4 | 1 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 0 |
| Хулд | 3 | 4 | 6 | 7 | 0 | 0 | 0 | 1 |
| Луус | 2 | 2 | 6 | 5 | 0 | 1 | 0 | 0 |
| Дэлгэрхангай | 5 | 8 | 11 | 15 | 1 | 0 | 1 | 0 |
| Сайхан-Овоо | 3 | 1 | 5 | 5 | 0 | 0 | 0 | 0 |
| Эрдэнэдалай | 25 | 18 | 22 | 16 | 0 | 0 | 1 | 0 |
| Сайнцагаан | 435 | 520 | 45 | 65 | 3 | 2 | 3 | 4 |
| Адаацаг | 5 | 7 | 8 | 10 | 0 | 0 | 1 | 0 |
| Дүн | 495 | 572 | 135 | 160 | 5 | 5 | 7 | 8 |

XV. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 7 сарын байдлаар

2018.08.08

| Сумд | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | | Бүгд үзлэг | | Халдварт өвчин бүгд | | үүнээс /зарим үзүүлэлтээр/ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сүрьеэ | | вируст гепатит | | тэмбүү | | трихомониаз | |
| | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 | 2017 | 2018 |
| Дц | 156 | 159 | 1117 | 975 | 6 | 24 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 |
| Дн | 167 | 105 | 3169 | 1763 | 3 | 4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 1 |
| Гу | 98 | 125 | 2977 | 2391 | 37 | 5 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 |
| Цд | 84 | 110 | 1379 | 1157 | 8 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бж | 129 | 106 | 1398 | 1829 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Өш | 163 | 155 | 2915 | 2209 | 2 | 4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 2 | 1 |
| Гс | 107 | 106 | 1550 | 1870 | 8 | 6 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Өт | 75 | 72 | 2531 | 2224 | 7 | 5 | 1 | 0 | 0 | 1 | 3 | 2 | 2 | 2 |
| Хд | 92 | 125 | 2003 | 1827 | 4 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 | 0 | 1 |
| Лс | 108 | 154 | 3010 | 1568 | 10 | 9 | 0 | 0 | 0 | 1 | 3 | 6 | 1 | 2 |
| Дх | 77 | 89 | 2711 | 2292 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 | 0 |
| Со | 122 | 130 | 1907 | 1315 | 3 | 3 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 0 |
| Эд | 387 | 372 | 7056 | 5638 | 16 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 |
| Ад | 174 | 180 | 6834 | 5266 | 4 | 3 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Сц | 3330 | 3698 | 67984 | 65804 | 219 | 171 | 11 | 5 | 2 | 3 | 12 | 25 | 20 | 22 |
| Мд | 320 | 276 | 336 | 299 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Эб | 252 | 233 | 228 | 183 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| МУЭ төв | 528 | 556 | 1555 | 1332 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| ДҮН | 6369 | 6751 | 110660 | 99942 | 329 | 240 | 21 | 9 | 4 | 6 | 19 | 40 | 31 | 31 |

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

XVI.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ 2018 оны 7-р сар

2018.08.08 Мян.төг

| Халамжийн төрүүд | хамрагдсан хүн | Гүйцэтгэл |
|---|---|---|
| Халамжийн тэтгэвэр | 791 | 756,231.1 |
| Нөхцөлт мөнгөн тэтгэмж | 858 | 352,154.7 |
| *Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд олгох* | 518 | 207,241.40 |
| *Байнгын асаргаа шаардлагатай ХБ хүүхдийг асарч байгаа* | 168 | 66,531.70 |
| *Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид* | 22 | 12,936.10 |
| *Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа* | 12 | 7,878.00 |
| *Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа* | 2 | 630.80 |
| *Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа* | 136 | 56,936.70 |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж | 895 | 103,487.30 |
| Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ /38+…+43/ | 91.00 | 13,991.50 |
| Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж /45+...+51/ | 681 | 227,542.4 |
| *Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн цэцэрлэгийн хоолны үнийн хөнгөлөлт* | 0 | 0.00 |
| *16 хүрэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж* | 170 | 145,522.40 |
| *3 хүртэлхи насны ихэр хүүхдэд жилд нэг удаа* | 6 | 12,000.00 |
| *Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа* | 490 | 52,020.00 |
| *3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа* | 0 | 0.00 |
| *18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа* | 0 | 0.00 |
| *Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа* | 15 | 18,000.00 |
| 0-03 насны хүүхэд асарсны тэтгэмж | 2577 | 700,051.80 |
| Өрх толгойлсон эцэг, эх | 72 | 42,960.00 |
| Хүнс тэжээл нийгмийн хамгаалалын хөтөлбөрт | 0 | 0.00 |
| Насны хишиг | 2446 | 403,905.00 |
| Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж | 4434 | 617,060.00 |
| Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж | 525 | 117,870.00 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж/ | 85 | 19,458.50 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж, хөнгөлөлт | 30 | 29,030.00 |
| Зарлагын нийт дүн | 13,485 | 3,383,742.3 |

XVII.ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ

| | | Хэмжих нэгж | 2018 он | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 р сар | 2 р сар | 3 р сар | 4 р сар | 5 р сар | 6 р сар | 7-р сар |
| 1. Малын үнэ /мян.төг/ | | | | | | | | | |
| Тэмээ | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 1,103.8 | 1088.5 | 1046.2 | 1162.5 | 1160.8 | 1025.4 | 1083.3 |
| | эм | тол | 920.8 | 923.1 | 861.5 | 929.2 | 922.5 | 792.3 | 895.8 |
| Өсвөр насны | эр | тол | 645.8 | 650 | 595.8 | 670.8 | 665 | 610 | 642.3 |
| | эм | тол | 633.3 | 637.5 | 620.8 | 629.2 | 625 | 583.3 | 625 |
| Адуу | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 736.7 | 739.3 | 740.8 | 737.9 | 750 | 675 | 696.4 |
| | эм | тол | 639.3 | 625 | 644 | 665.4 | 684.6 | 614.3 | 646.4 |
| Өсвөр насны | эр | тол | 482.7 | 478.6 | 497.2 | 527 | 523.1 | 465.4 | 487.5 |
| | эм | тол | 472.3 | 470.8 | 489.4 | 519.2 | 503.8 | 457.7 | 475 |
| Үхэр | | | | | | | | | |
| Нутгийн үүлдрийн, нас гүйцсэн | эр | тол | 976.7 | 1026.7 | 998.7 | 988.5 | 996.2 | 953.8 | 917.7 |
| | эм | тол | 871.4 | 835.7 | 838.7 | 834.6 | 888.5 | 838.5 | 792.3 |
| Өсвөр насны | эр | тол | 603.6 | 596.4 | 606.4 | 714.3 | 703.6 | 566.9 | 596.4 |
| | эм | тол | 589.3 | 571.4 | 581.8 | 619.2 | 630.8 | 555.4 | 566.7 |
| Хонь, Ямаа | | | | | | | | | |
| Нас гүйцсэн хонь | эр | тол | 137.3 | 134 | 134 | 144 | 153.8 | 140.7 | 135.3 |
| | эм | тол | 97.9 | 93.2 | 92.7 | 98.5 | 103.6 | 98.6 | 92.1 |
| Нас гүйцсэн ямаа | эр | тол | 131.3 | 94.3 | 95.3 | 102.5 | 106.8 | 97.9 | 95 |
| | эм | тол | 95.4 | 72.1 | 74.6 | 79.2 | 78.8 | 69.6 | 67.5 |
| 2.Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ/мян.төг/ | | | | | | | | | |
| Тэмээний ноос | | кг | - | - | - | | | 15.0 | 14 |
| Ямааны ноолуур | | кг | - | 70.0 | 90.0 | 93.0 | 97 | 90.0 | 85 |
| Тэмээний шир | | ш | 18.0 | 20.0 | 20.0 | 25.0 | 25.0 | 25.0 | - |
| Адууны шир | | ш | 20.0 | 20.0 | 20.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |
| -2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир | | ш | 25.0 | 25.0 | 25.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |
| -2 м- ээс дээш хэмжээтэй үхрийн шир | | ш | 30.0 | 30.0 | 30.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |
| Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс | | ш | 5.5 | 5.0 | 5.0 | 4.0 | 4.0 | 5.0 | 1.5 |
| Ямааны ноолууртай, өлөнтэй арьс | | ш | 36.0 | 40.0 | 35.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - |

# XVIII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

2018.08.08

| | Үзүүлэлт | 2017 | 2018 | 17/16 хувь |
|---|---|---|---|---|
| | Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо | 30086 | 30528 | 101.5 |
| | Бүх хэрэг | 126 | 169 | 134.1 |
| Хэргийн өнгө | Хүнийг санаатай алах гэмт хэрэг | 2 | 2 | 100.0 |
| | Хүчиндэх гэмт хэрэг | 0 | 6 | 0.0 |
| | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 3 | 4 | 0.0 |
| | Дээрэмдэх гэмт хэрэг | 1 | 0 | 0.0 |
| | Булаалт | 0 | 0 | 0.0 |
| | Танхайн хэрэг | 0 | 0 | 0.0 |
| | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 62 | 50 | 80.6 |
| | Бусдын эд хөрөнгийн хулгай | 30 | 71 | 236.7 |
| | Малын хулгай | 14 | 11 | 0.0 |
| | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг | 14 | 17 | 121.4 |
| | Залилангийн хэрэг | 3 | 6 | 200.0 |
| | Албан тушаал | 0 | 0 | 0.0 |
| | Бусад | 11 | 13 | 0.0 |
| нөхцөл | Эмэгтэй хүн оролцсон | 16 | 6 | 37.5 |
| | Согтуугаар | 30 | 22 | 73.3 |
| | Бүлэглэж | 2 | 12 | 600.0 |
| | Хүүхэд оролцсон | 0 | 5 | 0.0 |
| | Илрээгүй хэрэг | 25 | 97 | 388.0 |
| | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 6 | 4 | 66.7 |
| хэргийн ангилал | Хөнгөн | 79 | 105 | 132.9 |
| | Хүндэвтэр | 56 | 0 | 0.0 |
| | Хүнд | 13 | 64 | 492.3 |
| | Онц хүнд | 13 | 0 | 0.0 |
| | Гэмт хэрэгт холбогдогсод | 101 | 74 | 73.3 |
| | Учирсан бүх хохирол /сая.төг/ | 372.6 | 401.2 | 107.7 |
| | Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/ | 381.2 | 195.8 | 51.4 |
| | Илрүүлэлтийн хувь | 75.5 | 48.8 | 64.6 |
| | 18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/ | 42 | 55 | 132.2 |

## XIX. ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, сумаар

2018.08.08

| сум | 18 ба түүнээс дээш насны хүн | 18 -аас дээш насны 10000 хүнд ногдох | Бүх хэрэг | Холбогдогч | Хохирол /мян.төг/ | Золгүй учрал | Хүн амь | хүчин | дээрэм | булаалт | танхай | бусдын бие махбодьд гэмтэл учруулсан | бусдын өмчийн хулгай | малын хулгай | Тээврийн хэрэгс-лийн хөдөлгөөний аюулгүй байдлын | гал түймэр | албан тушаал | Залилан | бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дэлгэрцогт | 1106 | 9 | 11 | | 11206.5 | | | | | | | 1 | 5 | 1 | 3 | | | | 1 |
| Дэрэн | 1363 | 7 | 5 | 1 | 18150.0 | | | | | | | 1 | 1 | 1 | 1 | | | 1 | |
| Говь-Угтаал | 1068 | 0 | 6 | 6 | 8100.0 | | | | | | | 2 | 2 | 1 | | | | | 1 |
| Цагаандэлгэр | 694 | 0 | 4 | 1 | 8835.0 | 1 | | | | | | 1 | 2 | | | | | | |
| Баянжаргалан | 756 | 0 | 3 | 2 | 6513.7 | | | | | | | 1 | 1 | | | | | | 1 |
| Өндөршил | 973 | 10 | 2 | | 3500.0 | | | | | | | | 1 | | | | | 1 | |
| Гурвансайхан | 1449 | 7 | 8 | 5 | 18884.0 | | 1 | | | | | 4 | 3 | | | | | | |
| Өлзийт | 1607 | 0 | 6 | 2 | 5100.0 | 1 | 1 | | | | | 2 | 1 | 1 | | | | | |
| Хулд | 1612 | 0 | 7 | 4 | 44140.0 | | | 1 | | | | 1 | 1 | | 3 | | | | 1 |
| Луус | 1239 | 0 | 7 | 5 | 19300.0 | | | | | | | 3 | 2 | 1 | 1 | | | | |
| Дэлгэрхангай | 1489 | 0 | 5 | 2 | 3500.0 | 2 | 1 | | | | | 2 | | | | | | | |
| Сайхан-Овоо | 1470 | 0 | 3 | 1 | 1200.0 | | | | | | | 1 | 2 | | | | | | |
| Эрдэнэдалай | 3685 | 3 | 9 | 5 | 27000.0 | | | 1 | | | | 5 | 1 | 2 | | | | | |
| Сайнцагаан | 10074 | 18 | 75 | 27 | 168905.0 | 2 | | 3 | | | | 17 | 39 | 2 | 4 | | | 4 | 4 |
| Адаацаг | 1943 | 5 | 7 | 4 | 12160.0 | | 1 | | | | | 2 | 2 | 1 | 1 | | | | |
| Бусад | 0 | 0 | | | | | | | | | | | | | | | | | |
| Бүгд | 30528 | 8 | 158 | 65 | 356494.2 | 6 | 4 | 5 | 0 | 0 | 0 | 43 | 63 | 10 | 13 | 0 | 0 | 6 | 8 |



**Материалыг бэлтгэсэн:**


**Т.Бямбасүрэн**
**С. Доржханд**
**Г.Ариунжаргал**
**Н.Түвшинжаргал**

**Утас 70593714, 70593715**


**2018 оны 08 сарын 8**

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЭНХТУЯА